

ТАНИЛЦУУЛГА

*“Ээлжийн амралт олгох,
ээлжийн амралтын цалин тооцох
журам”-ын төслийн тухай*

Монгол Улсын Их Хурлаас 1999 онд баталсан Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасны дагуу ажил олгогч нь ажилтанд олгох ээлжийн амралтын хугацааг тогтоож, мөн хуулийн 55 дугаар зүйлийн дагуу ээлжийн амралтын олговрыг олгож байна.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар баталсан “Ээлжийн амралт олгох заавар” болон “Ээлжийн амралтын олговор тооцох журам”-аар ээлжийн амралт, түүний хугацаа болон олговрыг нарийвчлан зохицуулсан.

Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 99 дүгээр зүйлээр ээлжийн амралт, түүний хугацааг, 110 дугаар зүйлээр ээлжийн амралтын цалинтай холбоотой зохицуулалтыг тусгасан.

Уг хуульд ээлжийн үндсэн амралтын хугацааг ажлын 15 өдрөөр, нэмэгдэл амралтыг ажилтны ажилласан хугацаатай уялдуулан олгохоор заасан ба ажилтан ээлжийн амралтаа тухайн жилдээ багтаан хэсэгчлэн эдлэх зохицуулалтыг тусгасан. Ажилтны хэсэгчлэн амрах ээлжийн амралтын аль нэг хугацаа нь ажлын 10 өдрөөс багагүй байх юм.

Мөн ажилтан хөдөлмөрийн гэрээ байгуулснаас хойш 6 сарын дараа ээлжийн амралт эдлэх эрх үүсгэхээр, ээлжийн амралтын олговор гэдгийг ээлжийн амралтын цалин байхаар, ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд түүний цалинг 1.5 дахин нэмэгдүүлэн олгохоор тус тус заасан.

Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 99 дүгээр зүйлийн 99.10-т “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасан.

Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журмын төсөл нь Нийтлэг үндэслэл, Ээлжийн амралтын хугацаа тооцох, Ээлжийн амралтын цалин тооцох гэсэн гурван бүлэгтэй байх ба журмын нэгдүгээр хавсралтаар “Ээлжийн амралт олгох тухай мэдэгдэл”, хоёрдугаар хавсралтаар “Ээлжийн амралт тооцооны маягт”-ыг тус тус батлахаар боловсрууллаа.

Журмын төсөлд хуулийн холбогдох заалтуудыг нарийвчлан тодотгож жишээ, тайлбарыг оруулж дараах байдлаар тусгасан.Үүнд:

1.Ээлжийн үндсэн амралтын өдрийг тооцох ажлын жилийг тооцох;

2.Ажлын бүтэн бус цагийн ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацааг тооцох;

3.18 насанд хүрээгүй ажилтан ээлжийн амралт эдлэх ажлын жилд 18 насанд хүрсэн бол түүний ээлжийн амралтын хугацааг амралтын хугацааг тооцох;

4.Ажилласан хугацаанд ногдох ээлжийн үндсэн амралтын хугацааг тооцох;

5.Ээлжийн амралтын хугацааг тооцох ажиллаагүй үеийн хугацааг тодорхойлох;

6.Ээлжийн амралтын цалинг тооцох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүний тухай;

7.Ээлжийн амралтыг хэсэгчлэн эдлэх бол хэсэгчлэн эдлэх ээлжийн амралтын цалинг тооцох;

8.Ээлжийн амралтын цалинг тооцох нэг өдрийн цалин хөлсийг тодорхойлох;

9.Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь цуцлагдсан эсхүл дуусгавар болсон ажилтны ээлжийн амралтын хугацаа, ээлжийн амралтын цалинг тооцох хувилбар зэрэг болно.

Ээлжийн амралтын хугацаа болон цалинг Хөдөлмөрийн тухай хууль болон энэхүү журмаар тогтоосон зохицуулалтаар тооцох бөгөөд эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбаруудад хэрэглэх юм.